

**1. Япон Улсын Нийтийн Тэтгэврийн системийн талаарх Чухал Мэдээллүүд: Үндэсний Тэтгэврийн систем**

- (1) Япон улсад оршин суухаар бүртгүүлсэн, 20-59 насны бүх хүмүүс иргэний харьяалалаас үл хамааран Үндэсний Тэтгэврийн системд хамрагдаж, хуулийн дагуу шимтгэл төлөх үүрэгтэй.
- (2) Нийтийн тэтгэврийн систем (Үндэсний Тэтгэврийн системийг багтаагаад) нь санхүүгийн өөр хоорондын дэмжлэг бүхий тогтолцооноос бүрддэг.
- (3) Нийтийн тэтгэврийн систем нь өндөр- настны тэтгэврээс гадна хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр болон тэжээгчээ алдсаны халамжийн тэтгэврийг хамардаг.
- (4) Япон улсын засгийн газраас тэтгэврийн тэтгэмжийн сангийн зарим хэсгийг санхүүжүүлдэг.
- (5) Таны нийтийн тэтгэврийн шимтгэлийг “нийгмийн даатгалын шимтгэл” гэх ба энэ нь татварын суутгалаас хамааран өөрчлөгдөнө.

**2. Сар Бүрийн Шимтгэл**

Үндэсний тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ нь 2025 оны 4-р сараас 2026 оны 3-р сар хүртэл нэг сард ¥17,510 байна. Та шимтгэлээ банк, бусад санхүүгийн байгууллагууд, шуудангийн салбар болон 24 цагийн дэлгүүрт бэлнээр төлөх боломжтой. Түүнчлэн та банкны автомат гуйвуулга, Интернет төлбөр тооцоо эсвэл кредит карт ашиглан төлөх боломжтой.

**3. Үндэсний Тэтгэврийн Тэтгэмжүүд****(1) Өндөр настны Үндсэн Тэтгэвэр**

Хэрэв та дор хаяж 10 жилийн турш Үндэсний Тэтгэврийн шимтгэл төлсөн бөгөөд холбогдох шаардлагыг хангаж буй тохиолдолд, та 65 нас хүрээд Өндөр настны Үндсэн Тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

**(2) Хөдөлмөрийн Чадвараа Алдсаны Үндсэн Тэтгэвэр**

Хэрэв та Үндэсний Тэтгэврийн системд хамрагдаж байх хугацаандаа өвчилсөн эсвэл гэмтсэний улмаас тухайн өвчин эсвэл гэмтэл нь 1 эсвэл 2-р зэргийн хөдөлмөрийн чадвар алдалтанд заасан хөдөлмөрийн чадвар алдалтыг үүсгэсэн тохиолдолд, та Хөдөлмөрийн Чадвараа Алдсаны Үндсэн Тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

**(3) Тэжээгчээ Алдсаны Халамжийн Үндсэн Тэтгэвэр**

Үндэсний Тэтгэврийн системд даатгагдсан иргэн нас барахад хүүхдүүдээ асарч үлдсэн гэрийн бүлийн хүн эсвэл хүүхдүүд нь Халамжийн Үндсэн Тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд JPS (Япон Улсын Үндэсний Тэтгэврийн Үйлчилгээ) Салбар Оффис эсвэл өөрийн оршин суугаа орон нутгийн оффист (Үндэсний Тэтгэврийн хэсэг) хандана уу.

Доорх <https://www.nenkin.go.jp/international/index.html> дээрх JPS вебсайтад зочилно уу Япон Улсын Тэтгэврийн Үйлчилгээ Дарах

Тэтгэвэр тогтоолгох талаар ерөнхий мэдээлэл авахын тулд, доорх утсаар бидэнтэй холбогдоно уу;

“Nenkin Kanyusha Dial” 0570-003-004 (дотоодод хямдралтай тарифаар)

Хэрэв таны утасны дугаар 050-иар эхлэсэн бол, доорх дугаарт залгана уу: 03-6630-2525 (энгийн тарифаар)

Ажиллах цаг: 8:30 – 19:00 Даваа – Баасан  
9:30 – 16:00 сар бүрийн хоёрдахь Бямба гараг

**Баярын өдрүүдээр ажиллахгүй** (сар бүрийн хоёрдахь Бямба гарагаас гадна), 12-р сарын 29-нөөс 1-р сарын 3 хүртэл

Япон улсад оршин суухаар бүртгүүлсэн 20-59 насны бүх хүмүүс иргэний харьяалал эсвэл оршин суух хугацаанаас үл хамааран Япон улсын нийтийн тэтгэврийн систем болох Үндэсний Тэтгэврийн системд хамрагдаж, хуулийн дагуу шимтгэл төлөх үүрэгтэй. (Оршин суух хугацаанаас үл хамааран Япон улсад оршин суухаар бүртгүүлсэн бол Япон улсын нийтийн тэтгэврийн систем болох Үндэсний Тэтгэврийн системд хамрагдаж, хуулийн дагуу шимтгэл төлөх үүрэгтэй.) Хэрэв та шимтгэл төлөхөд санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан бол шимтгэлээс чөлөөлөх систем эсвэл төлбөр хойшлуулах системд хамрагдах өргөдлийг **жил бүр** гаргах боломжтой. (Энэхүү өргөдлийг **жил бүр гаргах боломжтой**). Бид таны өргөдөл, өнгөрсөн хугацааны орлогыг шалгаж үзээд шаардлага хангасан гэж үзвэл чөлөөлөлт/хойшлуулалтыг олгоно. Энэхүү үйл явцыг дагаснаар та ирээдүйд өндөр настны тэтгэвэр болон санамсаргүй байдлаар гэмтэж, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэвэр авах шаардлагад багтсан даатгалын хүчинтэй хугацааг бий болгож буй болно.

**(1) Шимтгэл төлөлтөөс бүрэн эсвэл хэсэгчилэн чөлөөлөгдөх өргөдөл**

Та, таны гэр бүлийн хүн (таньгай хамт амьдардаггүй хүнийг багтаагаад) эсвэл өрхийн тэргүүний өнгөрсөн жилийн орлого тодорхой заасан дүнгээс доош эсвэл дээр дурьдсан хүмүүсийн хэн нэг нь хөдөлмөр эрхлэдэггүй тохиолдолд, тухайн жилд бүрэн эсвэл хэсэгчилсэн чөлөөлөлтөнд хамрагдах өргөдөл гаргаж болно. Таныг шаардлага хангасан гэж үзвэл чөлөөлөлтийг олгоно. (Хэсэгчилсэн чөлөөлөлт нь таниас үлдэгдэл шимтгэлийг төлөхийг шаарддаг болохыг анхаарна уу; хэрэв та үлдэгдэл шимтгэлийг төлөөгүй тохиолдолд, хэсэгчилсэн чөлөөлөлтийн хугацаа хүчингүй болох ба төлөгдөөгүй хугацаанд тооцогдоно.)

**(2) Шимтгэл төлөлтийг хойшлуулах өргөдөл**

Хэрэв та 50-иас доош настай (оюутныг оролцуулахгүй) бөгөөд та эсвэл таны гэр бүлийн хүний (таньгай хамт амьдардаггүй хүнийг багтаагаад) өнгөрсөн жилийн орлого тодорхой заасан дүнгээс доош тохиолдолд, төлбөр хойшлуулах өргөдөл гаргаж болно. Таныг шаардлага хангасан гэж үзвэл хойшлуулалтыг олгоно.

**ӨРГӨДӨЛ ДЭЭРХ ТЭМДЭГЛЭЛҮҮД****● Өргөдөл гаргаж буй жил**

- Чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд хамрагдах нэг жил нь 7-р сард эхэлж, дараагийн 6-р сард дуусна. (7-р сард эхэлж, дараагийн 6-р сард дуусна.)
- Хэрэв та дараагийн жилд чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд үргэлжлүүлэн хамрагдахыг хүсвэл жил бүрийн 7-р сард өргөдлөө гаргах шаардлагатай.

**● Өнгөрсөн жил болон энэ жилийн өргөдөл**

- Өнгөрсөн жилүүдийн хувьд: Та өргөдөл гаргасан огнооноос өмнөх өнгөрсөн 25 сарыг нөхөх чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд хамрагдах өргөдөл гаргах боломжтой (хэрэв та тухайн 25 сарын хугацаанд тодорхой саруудад шимтгэл аль хэдийнэ төлсөн тохиолдолд, төлөгдсөн шимтгэл чөлөөлөгдөхгүй).
- Энэ жилийн хувьд: Та энэ жил чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд хамрагдах өргөдөл гаргахад энэ нь 6-р сар хүртэлх хугацааг хамарна. (Жишээлбэл, хэрэв та 1-ээс 6-р сарын хооронд өргөдөл гаргасан бол тухайн өргөдөл нь энэ жилийн 6-р сар хүртэлх хугацааг хамарна.)
- Нэг өргөдөл 7-р сараас дараагийн 6-р сар хүртэлх 12 сарыг хамарна. Хэрэв та удаан хугацааны чөлөөлөлтөнд хамрагдахыг хүсвэл нэгээс илүү өргөдөл бэлтгэх шаардлагатай.
- Жич:** Та өргөдөл гаргасан огнооноос өмнөх өнгөрсөн 25 сарыг нөхөж өргөдөл гаргах боломжтой. Өнгөрсөн даатгалын хугацааг хүчинтэй болгохын тулд бид танд өргөдлөө аль болох эрт гаргахыг зөвлөж байна. Хэрэв таны өргөдөл хойшлосон тохиолдолд та хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авах эрхгүй болж болзошгүй.

**● Бидэнд шаардлагатай бичиг баримтууд**

Хэрэв та ажилгүйдэл, дампуурал эсвэл бизнесээ зогсоосноос шалтгаалан чөлөөлөлтөнд хамрагдах өргөдөл гаргаж буй тохиолдолд, бидэнд таны хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийн гэрчилгээ (Koyohoken Jukyu Shikakusha Sho) эсвэл хөдөлмөр эрхлэлтийн даатгалд даатгуулагчийн цуцлалтын баримтын (Koyohoken Hihokensha Rishokuho) аль нэгийг хуулбар зэрэг холбогдох нотлох бичиг баримт шаардлагатай. Шаардлагатай нотолгооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд өөрийн оршин суугаа орон нутгийн оффис эсвэл JPS Салбар Оффист хандана уу.

**● “Өөрийн дугаар” ашиглан төрөл бүрийн өргөдөл гаргах тохиолдолд**

Хэрэв та “Хувийн дугаар”-аа оролцуулан орон нутгийн захиргааны албанд өргөдөл гаргах бол өөрийн “Хувийн дугаар”-тай үнэмлэхээ авчрах хэрэгтэй. Хэрэв танд уг үнэмлэх байхгүй бол доорх (1) ба (2) дугаарт дурдсан бичиг баримтуудыг авчирна уу.

Хэрэв та өргөдлөө шуудангаар илгээх бол “Хувийн дугаар”-тай үнэмлэхнийхээ нүүр ба ард тал тус бүрийн хуулбарыг хавсаргана. Хэрэв танд уг үнэмлэх байхгүй бол доорх (1) ба (2) дугаарт дурдсан бичиг баримтуудын хуулбарыг илгээнэ уу.

(1) Таны “Хувийн дугаар”-ыг харуулсан оршин суух бүртгэлийн баталгаажуулсан хуулбар, эсвэл “Хувийн дугаар” олгосныг баталгаажуулсан албан бичиг (таны оршин суух бүртгэл дээрх нэр ба хаяг ижил тохиолдолд).

(2) Таны жолооны үнэмлэх, паспорт, оршин суугчийн үнэмлэх, эсвэл таныг “Хувийн дугаар”-ын жинхэнэ эзэмшигч болохыг баталгаажуулсан, дээрхтэй дүйцэхүйц бичиг баримт (Дэлгэрэнгүйг Тэтгэврийн байгууллагын салбараас лавлана уу.)

**ӨРГӨДЛИЙГ ХААНА ГАРГАХ ВЭ**

Бүрэн гүйцэд бөглөсөн өргөдлийг өөрийн оршин суугаа орон нутгийн оффис эсвэл JPS Салбар Оффист өгнө үү. Та дээрх газрууд руу өргөдлөө шуудангаар илгээж болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд өөрийн оршин суугаа орон нутгийн оффис эсвэл JPS Салбар Оффист хандана уу.

Өргөдлийн маягыг хэрхэн бөглөх талаар дараахь хүүдаснаас хар.



Үндэсний Тэтгэврийн Шимтгэлээс Чөлөөлөгдөх / Төлөлт Хойшлуулах Өргөдлийг хэрхэн бөглөх талаар анхааралтай уншина уу. **Улаан өнгөөр бичсэн жишээ оруулгыг даган, холбогдох мэдээллийг Япон хэл, Латин үсэг эсвэл тооны (Араб тоо) аль нэгээр оруулна уу. Хэрэв өргөдлийг бүрэн гүйцэд бөглөөгүй эсвэл шаардлагатай мэдээлэл дутуу тохиолдолд, бид таны өргөдлийг буцааж, таниас тухайн мэдээллийг Япон хэлээр оруулахыг шаардахыг анхаарна уу. Энэ нь өргөдлийг хойшлуулж болзошгүй.**

Өргөдөл гаргасан огноо (он/сар/өдөр), өргөдөл гаргасан үеийн хаяг, нэрээ паспорт дээр бичигдсэнтэй ижил Латин үсгээр оруулна уу.

Өөрийн 12 орон бүхий “Өөрийн Дугаар” (таны Япон улс дахь Хувийн Дугаар) эсвэл 10 орон бүхий Үндсэн Тэтгэврийн Дугаарыг оруулна уу ①. (Үндсэн Тэтгэврийн Дугаарыг зүүн талд буй хэсэгт оруулна уу.)

Өөрийн нэрийг ③, өөрийн гэр бүлийн хүний нэрийг ⑤, өрхийн тэргүүний нэрийг ⑦-д оруулна уу. (Хэрэв та энэ жилийн хувьд чөлөөлөлт / хойшлуулалтанд хамрагдахаар өргөдөл гаргаж буй бол одоогийн мэдээллээ оруулна уу. Өнгөрсөн жилийн хувьд өргөдөл гаргаж буй бол өргөдөл гаргаж буй жилийн сүүлийн огноогоор эдгээр мэдээллийг оруулна уу. Жишээлбэл, хэрэв та 2023 оны чөлөөлөлтөнд хамрагдахаар өргөдөл гаргаж буй бол нэр бүрийг 2024 оны 6-р сарын 30-ны байдлаар оруулна уу.)  
\* Танай өрхийн тэргүүн (тухайн гэр бүлийн гол орлого ологч хүн) таны Япон Улсад Оршин Суугчийн Бүртгэлд (JUMINHYO) бүртгэгдсэн байдаг.

Өмнөх жилийн 12-р сарын 31-ний байдлаар та, таны гэр бүлийн хүн эсвэл өрхийн тэргүүний 16-18 насны гэр бүлийн гишүүд байвал ⑪-д оруулна уу. Гурван мөр байдаг: Эхний мөрөнд өөрийн, хоёрдахь мөрөнд өөрийн гэр бүлийн хүний, гуравдахь мөрөнд өрхийн тэргүүний мэдээллийг оруулна уу. Жишээлбэл, хэрэв өрхийн тэргүүн гэр бүлийн нэг гишүүнтэй бол гуравдахь мөрөнд ① тэмдэглэгээг хийж хүний тоог 1 гэж ( ) дотор байрлуулна уу.

Хэрэв та чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд үргэлжлүүлэн хамрагдахыг хүсвэл жил бүрийн 7-р сард өргөдлөө гаргах шаардлагатай. Үйл явцыг хялбар болгохын тулд бид таниас дараахь нэмэлт асуултуудыг асууна ⑬:  
1. Хэрэв бид энэ удаад танд бүрэн чөлөөлөлт эсвэл хойшлуулалтыг олгосон бөгөөд дараагийн жилд мөн олгоно гэж үзвэл та үргэлжилсэн бүрэн чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд хамрагдах өргөдөл гаргахыг хүсч байна уу? Хэрэв үгүй бол, ① тэмдэглэгээг “希望しません” (үгүй) дээр байрлуулна уу.  
2. Түүнчлэн, хэрэв бид энэ удаад танд хойшлуулалтыг олгосон бөгөөд дараагийн жилд бүрэн чөлөөлөлтийг олгох боломжтой гэж үзвэл та дараагийн жилд бүрэн чөлөөлөлтөнд хамрагдах өргөдөл гаргахыг хүсч байна уу? Хэрэв үгүй бол, ① тэмдэглэгээг “希望しません” (үгүй) дээр байрлуулна уу.  
Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд JPS Салбар Оффис эсвэл өөрийн оршин суугаа орон нутгийн оффист хандана уу.

Маягтын эхний хэсэгт та даатгуулагч хүн болон өргөдөл гаргагчийн хувиар чөлөөлөлт эсвэл хойшлуулалтанд хамрагдахаар өргөдөл гаргаж буйгаа дурьдана уу. Түүнчлэн та энд өөрийн болон өөрийн гэр бүлийн хүн, өрхийн тэргүүний талаарх мэдээлэл болон өнгөрсөн жилийн орлогын мэдээлэл бүрэн гүйцэд бөгөөд үнэн зөв болохыг мэдэгдэх шаардлагатай. Таны өргөдлийг шалгахад шаардлагатай хувийн мэдээллийг Япон Улсын Тэтгэврийн Үйлчилгээ (JPS) болон түүний орон нутгийн оффистой хуваалцахыг зөвшөөрч, тэдэнд эрх олгох шаардлагатай.

Утасны дугаараа ②-д оруулна уу. Холбогдох утсыг дугуйлна уу; 1. гэрийн утас, 2. гар утас, 3. Ажлын газрын утас, 4. бусад утас. Төрсөн он, сар, өдөр (ууу / mm / dd) ④-т, эхнэр / нөхрийнхөө төрсөн он, сар, өдрийг ⑥-д оруулна уу.

Хэрэв та, таны гэр бүлийн хүн эсвэл өрхийн тэргүүн тухайн өргөдөл гаргаж буй жилийн 1-р сарын 1-ний байдлаар Япон улсаас гадагш оршин сууж байсан бол, тухайн улсыг дурьдана уу. Жишээлбэл, хэрэв та тухайн өргөдөл гаргаж буй жил (2024 оны 7 сарын 1-ний өдөр) Япон улсад амьдарч буй бөгөөд 2024 онд хамрах өргөдөл гаргаж буй боловч 2024 оны 1-р сарын 1-ний байдлаар АНУ-д амьдарч байсан бол, өөрийн нэр болон “АНУ”-ыг оруулна уу. Хэрэв таны гэр бүлийн хүн өргөдөл өгсөн өдрөөс хойш Японд өөр хаягаар амьдардаг бол гэр бүлийн хүний хувийн дугаарыг оруулна уу (өнгөрсөн жилийн өргөдөл гаргасан тохиолдолд өргөдөл гаргах жилийн 6 сарын 30-ны байдлаар). Хэрвээ та, таны гэр бүлийн хүн, эсвэл өрхийн толгойлогч ⑩ дугаар дахь жил дотроо гадаад улсаас шилжин ирсэн, мөн гадаад улс руу нүүн шилжсэн тохиолдолд ⑧ дугаарт хамрагдах хүний нэр, он сар өдөр, улсын нэрийг бичнэ үү. (Тухайлбал, 2024 оны 11 сарын 1-ний өдөр АНУ-аас Япон улсад нүүн шилжиж ирсэн тохиолдолд “(таны нэр) 2024 оны 11 сарын 1-ний өдөр АНУ-аас нүүн шилжсэн” гэж бөглөнө үү.)

Та чөлөөлөлт эсвэл хойшлуулалт олгохыг хүсч буй жилийг (дөрвөн оронтой) оруулна уу. Тухайн өргөдөл гаргаж буй жил нь 7-р сараас дараагийн жилийн 6-р сар хүртэлх хугацааг хамарна. Жишээлбэл, 2024 онд өргөдөл гаргаж буй нь 2024 оны 7-р сараас 2025 оны 6-р сар хүртэлх хугацааг хамарна. Та өргөдөл гаргасан огнооноос өмнөх 25 хүртэлх сарын хугацааг нөхөж өргөдөл гаргах боломжтой. Гэсэн хэдий ч, та тухайн 25 сарын хугацаанд зарим саруудад аль хэдийнэ шимтгэл төлсөн бол, төлөгдсөн шимтгэл чөлөөлөгдөхгүй.

Хэрэв та, таны гэр бүлийн хүн эсвэл өрхийн тэргүүн ажлаасаа халагдсаны улмаас та чөлөөлөлтөнд хамрагдахаар өргөдөл гаргаж буй бол, ажлаас халагдсаны дараагийн өдрийн огноог (он/сар/өдөр) ⑫-д оруулна уу. Эхний мөрөнд өөрийн, хоёрдахь мөрөнд өөрийн гэр бүлийн хүний, гуравдахь мөрөнд өрхийн тэргүүний мэдээллийг оруулна уу. Хэрэв та нарын хэн нэгэн нь ажлаас халагдахаасаа өмнө хөдөлмөр эрхлэгчийн даатгалд хамрагдаж байсан бол ① тэмдэглэгээг сумны тэмдэгийн ⇒ баруун талд байрлах “あり” (тийм) дээр байрлуулан, тухайн даатгалыг нотлох бичиг баримтыг өгнө үү.

Энэ нь Үндэсний Тэтгэврийн Шимтгэлээс Чөлөөлөгдөх / хойшлуулах өргөдөл гаргах МАЯГТ ЮМ.

### 国民年金保険料免除・納付猶予申請書

日本年金機構理事長 あて 令和2024年7月1日 指定全額免除申請事務取扱者 市区町村 日本年金機構

以下のとおり免除・納付猶予を申請します。また、配偶者および世帯主の記入に漏れがないことを申し立てします。この申請に必要な本人、配偶者および世帯主に関する情報(所属情報、生手保険資格情報等)の提供について、市区町村 前住所地

〒123-4567 Tokyo-To, Suginami-Ku, Takaido Nishi, 1-2-3

住所: **Таны хаяг**

被保険者氏名: **Таны нэр JOHN SMITH**

基礎年金番号(10桁)で申請する場合は「①個人番号(または基礎年金番号)」欄に個人番号(または基礎年金番号)を記入してください。

① 個人番号(または基礎年金番号)	X X X X X X X X X X X X X X	② 電話番号	1. 自宅 2. 携帯電話 3. 勤務先 4. その他 080-XXXX-XXXX
③ 被保険者氏名	<b>Таны нэр JOHN SMITH</b>	④ 被保険者生年月日	<b>Таны төрсөн огноо</b> 5. 昭和 1990 8 10 7. 平成
⑤ 配偶者氏名	<b>Таны гэр бүлийн хүний нэр JANE SMITH</b>	⑥ 配偶者生年月日	<b>Таны гэр бүлийн хүний төрсөн</b> 5. 昭和 1990 10 1 7. 平成
⑦ 世帯主氏名	<b>Өрхийн тэргүүний нэр JAMES SMITH</b>	※ 世帯主氏名は被保険者または配偶者以外が世帯主である場合に記入してください。	
⑧ 特記事項	John Smith, U.S.A. John Smith moved from the U.S.A. on 2024/11/1 (配偶者が別世帯の場合) 配偶者の個人番号 (XXXX-XXXX-XXXX)		

⑨ 免除等区分

1. 全額免除 (保険料全額を免除)	2. 納付猶予 (保険料は納付せず)	3. 4分の3免除 (保険料1/4納付が必要)	4. 半額免除 (保険料1/2納付が必要)	5. 4分の1免除 (保険料3/4納付が必要)
--------------------	--------------------	-------------------------	-----------------------	-------------------------

⑩ 申請期間 平成 2024 年度分

⑪ 16歳以上19歳未満の扶養親族

被保険者	16歳以上19歳未満の扶養親族	あり ( )	なし
配偶者	16歳以上19歳未満の扶養親族	あり ( )	なし
世帯主	16歳以上19歳未満の扶養親族	あり ( 1 )	なし

⑫ 特例認定 (海外居住者等)

被保険者	1. 失業 平成2024年4月1日 ⇒ 雇用保険加入 (あり・なし)	2. 天災等	3. その他 ( )
配偶者	1. 失業 平成 年 月 日 ⇒ 雇用保険加入 (あり・なし)	2. 天災等	3. その他 ( )
世帯主	1. 失業 平成 年 月 日 ⇒ 雇用保険加入 (あり・なし)	2. 天災等	3. その他 ( )

⑬ 継続希望

1. 「全額免除」または「納付猶予」が承認された場合は、翌年度以降も同じ免除区分での免除申請を希望します。希望しない場合は、を○で囲んでください。

2. 1を希望した上で、納付猶予が承認された次の年度において全額免除の審査基準に該当する場合、その年度以降は全額免除を希望します。希望しない場合は、を○で囲んでください。

⑭ 備考

※ 所得に関する情報について、関係法令に基づき、申告義務がある場合には、正しく申告する必要があります。